



ХӨСӨГ ТРЕЙД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 22-08

Улаанбаатар хот

Г Ногдол ашиг хуваарилах тухай Г

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалт, 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн 2021 оны тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 1,093,434,902.03 төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 760,309,457.99 төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 333,125,444.04 төгрөгөөр, нийт орлогыг 580,352,542.15 төгрөгөөр, ашиг 74,378,927.30 төгрөгөөр тус тус тооцож тайлан тэнцлийн дүнг баталсугай.
2. Компани нь 2021 онд 74,378,927.30 төгрөгийн ашигтай ажиллаж, хуримтлагдсан ашгийн дүн 101,771,151.22 төгрөг болсон байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, цаашид компанийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт оруулахуйц хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан 2021 оны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.
3. 2022 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, компанийг илүү үр ашигтай ажиллуулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулахад идэвхи санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Эрдэнэсүх/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.МЯГМАРЖАВ